

НАРИЙНТЭЭЛ СУМ, БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2022.11.04

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл, тайлбар)
				он	түвшин		
<p>Нэг. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамаарах 25 заалтын хүрээнд (Сум, агентлагт хамаарах) Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.</p>							
	1.1.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	1.1.1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх	Хууль тогтоомжийн хүрээнд томилсон шийдвэрийн тоо	2021	2	3	2022 онд зохион байгуулагдсан төрийн албаны ерөнхий шалгалтанд 1 иргэн тэнцэж нөөцөд бүртгүүлсэн. Сүл ажлын байрны зарыг ТАСЗ-д хүргүүлж тусгай шалгалтанд тэнцсэн 1 иргэнийг Хүнс жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан ажилтаны ажлын байранд авч ажиллуулсан ба 07 сар хүртэл ажиллаад гарсан учир гэрээгээр ажилтан авч ажиллуулж байна. Төсөв төрийн сангийн мэргэжилтэний сүл ажлын байранд мэргэжил ур чадвараар тохирох нэг хүнтэй хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулан ажилласан боловч 2022 оны 07 сар хүртэл ажиллаад гарсан. Уг ажлын байрыг удаа дараа зарласан боловч тусгай шалгалтанд тэнцсэн хүн одоогоор байхгүй байна. Иймд санхүү албаны дарга болон ХАА-н тасгийн мэргэжилтэнд хавсруулан ажиллуулж байна. Төрийн захиргааны нийт ажлын байраас сүл ажлын байр 3 байна. Биеэлэлт 100

		1.1.2.Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.	ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийн тоогоор	2021	3	5	Төрийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт 1, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянасан дүгнэлт 5-ийг тухай бүр нь сумын цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээллэж ажилласан. Биелэлт 100%
		1.1.3.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах.	Хянуулсан ХАСУМ-ын тоогоор	2021	-	-	Хууль тогтоомжид заасан ХАСУМ хянуулах Төрийн захиргааны албан хаагч томилогдоогүй учир АТГ-т бичиг баримт хүргэгдээгүй. Биелэлт 100
1.2	1.2. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.		Зохион байгуулсан сургалт хамрагдсан албан хаагчийн тоо	2021	26 төрийн албан хаагч давхардсан ардсан тоогоор 71 удаа хамрагдсан	1371	2022 оны эхний хагас жилд мэргэшүүлэх багц сургалтаас гадна цаг үеийн шаардлагад нийцсэн мэдээлэл, мэдлэг чадварыг шуурхай олгох үүднээс богино хугацааны зорилтот сургалтанд албан хаагчдыг хамруулсан. Мэргэжлийн болон бусад 68 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 1371 албан хаагч оролцсон. Дээрх сургалтын 58 нь танхимаар, 10 нь цахимаар зохион байгуулагдсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7-4-10 20 удаагийн сургалтанд давхардсан тоогоор нийт 1136 албан хаагч албан хаагч хамрагдсан. ЗГХЭГ, Удирдлагын академийн богино хугацааны зорилтот сургалт 5 албан хаагч оролцсон. Төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдсан мэдээллийг хүн нэг бүрээр хөтөлж хүний нөөцийн системд оруулсан. Биелэлт 100
		1.2.1.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах.					
		1.2.2.Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	Боловсруулсан сургалтын хөтөлбөр, модуль	2021	-	4	Авлигын эсрэг хуулиар 4 ш постер бэлдэж цахим сүлжээнд байршуулан иргэдэд хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж байна. Биелэлт 70

		1.2.3.Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалтын тоо	2021	2	4	ХАСХОМ гаргадаг албан хаагчдад ХАСХОМ гаргах аргачлал болон Авлигын эсрэг хуулийн талаар 2022 оны 01 сард цахим сургалт зохион байгуулахад 12 албан хаагч хамрагдсан. Сумын Хамтарсан багийн пэйж хуудас болон өөрийн цахим хуудсаар дамжуулан "Авлигын эсрэг хуулийн зарим зүйл заалтуудыг бусад цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчилан ажиллаж байна. ЕБС-ийн дотуур байрны 36, 9-12 дугаар ангийн 47 сурагчдад Авлигын эсрэг сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 83 хүүхэд хамруулсан. 10 сард Авлигын эсрэг сургалтыг 1 удаа зохион байгуулж 23 иргэнийг хамруулсан. Биелэлт 100
--	--	---	---------------------------------	------	---	---	---

1.3	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогт олцоог бүрдүүлэх.</p>	1.3.1.Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.	Зохион байгуулсан арга хэмжээ	2021	ёс зүйн хороо 8	ёс зүйн хороо 8	<p>Төрийн байгууллага бүр ёс зүйн зөвлөлийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг судлах мөрдөх зорилгоор сургалт зохион байгуулах, иргэд олон нийтээс санал авах, ёс зүйн дэвтэр, ёс зүйн толан, алдааны сан хөтлөх, ёс зүйтэй байгууллага хамт олон болох зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Засгийн газрын 33 дугаар тогтоол, "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага", сэдвүүдээр сургалтын удирдамж боловсруулж 1 удаа сургалт зохион байгуулахад нийт 26 албан хаагч хамрагдлаа. ЕБС нь багш нарын харилцаа хандлага, заах арга барилын талаар санал асуулгыг 260 сурагч, 98 эцэг эхээс авч 4 багштай удирдлагын багаар уулзан зөвлөгөө анхааруулга өгсөн. Төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх болон албан томилолтоор ажиллах хугацаандаа согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, ажлын байранд албаны бус хувцаслах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх зөрчил гараагүй. Сумын хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гараагүй. ЗДТГ-ын 2, ИТХ-ын 1, ЕБС 3, Соёлын төв 1, нийт 7 албан хаагч сахилгын зөрчил гаргасан ба эдгээр албан хаагчидад Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасан хариуцлагуудыг хүлээлгэсэн. Биелэлт 100%</p>
-----	--	---	-------------------------------	------	-----------------	-----------------	--

		1.3.2.Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.	Зохион байгуулсан арга хэмжээ	2021	Дотоод хяналтын нэгжийн тоо 8	Дотоод хяналтын нэгжийн тоо 8	Байгууллага бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэй дотоодын хяналт шалгалтын зөвлөлийг байгуулан ажиллаж байгаа ба төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу явуулж байна. Хяналт шалгалтын мөрсөөр хэрэгжүүлэх зөвлөмжийн тухай бүр өгч хэрэгжилтийг хянан ажил Төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагаа, өмчийн ашиглалт хамгаалалт, төсөв санхүү, ажлын цаг ашиглалт, салбарын стандарт хангалт, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, гэсэн чиглэлээр ажлаа төлөвлөн ажилласан. Дотоод хяналтын ажил сайжирснаар байгууллагын эрсдэл тодорхой хэмжээгээр буурч байна. Биелэлт 100%
Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх.							
2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэжжүүлэх.	2.1.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	Үйлчилгээний төрлийн тоо	2021	151	266	Засаг даргын Тамгын газрын нэг цэлийн үйлчилгээний операторын үйлчилгээнээс нийт 266 лавлагаа гарсан байна. Иргэд лавлагаа авах зорилгоор аймгийн төв явж лавлагаа гаргуулж авах ажил багасч төрийн хүнд суртлыг арилган ажиллаж байна. Нийт 277 төрийн үйлчилгээг Операторын үйлчилгээгээр авах боломжтой байгаа. Сумын хэмжээнд нийт 251 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Биелэлт 100	

2.2	2.3.Төрийн чанар, хөндлөнгийн албан ажиллагааг тогтолцоог үйлчилгээг сайжруулах.	2.3.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.	ТББ-аар үнэлгээ хийлгэх	2021	-	1	Суманд үйл ажиллагаа явуулж буй ТББ болох Ахмадын хорооноос сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн "Ахмадаа сонсоё" сэдэвт төрийн захиргааны үйлчилгээтэй холбоотой хэлэлцүүлгийг сумын ахмадын хороо, ЗДТГ-тай хамтран зохион байгуулж гарсан санал, шүүмжлэл, сайшаал зэрэгт тулгуурлан ахмадын хорооноос Зөвлөмж гаргасан. Биелэлт 70
		2.3.3.Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх.	Үнэлгээ хийсэн тоо	2021	2	2	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, албан хаагчдын зан харилцаа, мэргэжлийн ур чадвар зэрэг үзүүлэлтээр хагас жил, Төрийн байгууллагуудын "Нээлттэй хаалга"-ны өдөрүүдээр ард ард иргэд үйлчлүүлэгчид, удирдлага, хамт олноос санал асуулга авч, гарсан санал, гомдолыг тухай бүрт нь шийдвэрлэн үйл ажиллагаандаа тусган ажилласан. Биелэлт 70
Зорилт 3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.							
	3.1. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	3.1.1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	Хугацаанд нь байршуулсан мэдээллийн тоо	2021	12 удаа	10 удаа	Орон нутгийн хөгжлийн сан болон тусгай сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад материалын хамт Шилэн дансны хуульд заасан хугацаанд батлагдсан маягтын дагуу гарган мэдээлж тайлагнаж байна. Мөн байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэл тавих багийн йргэдийн нийтийн хуралд мэдээлэл, тараах материал хэвлэн тараах зэргээр иргэдэд ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан. Биелэлт 100

		3.1.2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх.	Ил тод болгосон шийдвэрийн тоо	2021	7	14	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэчийг үнэлгээний хороо байгуулан тендер зарлан сонгон шалгаруулсан. Шалгарсан тухай мэдэгдлийг тендерт оролцсон болон шалгарсан ААНБ-д зэрэг хүргэж шийдвэрийг ил тод болгосон. Биелэлт 100
2.5	3.2 Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.	3.2.1.Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.	Санал, хэлэлцүүлэгийн тоо	2021	2	1	Орон нутгийн төсвийн төслийг хуулийн хүрээнд хийж тухайн байгууллагын хэрэгцээ шаардлага, бодит байдалд үндэслэн боловсруулан Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн. Биелэлт 70
		3.2.2.Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн нийтэд ил тод болгох	2021	1	1	Орон нутгийн төсвийн төслийн мэдээллийг Шилэн данс болон байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулан иргэд олон нийтэд ил тод болгосон. Мөн Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон сумын сайтад мэдээллийг байршуулсан. Биелэлт 100
		3.2.3. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн (захиргааны) байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх.	Хохирол гарсан нөхцөлд барагдуулсан байх	2021	0	0	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн байгууллагад учирсан хохирол гараагүй. Биелэлт 100
Зорилт 4.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.							
2.6	4.1.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг	4.1.1.Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх.	ХАА-г 100% цахимаар явуулсан байна.	2021	-	4	Худалдан авах ажиллагааг шууд худалдан авах ажиллагааны аргаар зохион байгуулагдаж байгаа ажлаас бусад 4 барааны тендер цахимаар зохион байгуулагдсан. Биелэлт 100

	нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	4.1.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.	Мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулах	2021	1	1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, мөн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, төсвийн гүйцэтгэл, хийгдсэн ажлын тайлан зэрэг материалыг Шилэн данс, сумын сайт, сумын нэгдсэн групп байршуулж байна. Биелэлт 100
		4.1.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан тоо	2021	12	11	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэлийг Худалдан авах ажиллагааны сайтад tender.gov.mn сайтад байршуулсан мэдээлж байна Биелэлт 100
Зорилт 5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.							
2.7	5.1.3. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	5.1.1.3. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, өрсөлдөөнт орчин бүхий бизнесийг дэмжин хөгжүүлэх.	.Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжин ажилласан байх	2021	-	1	ААНБ-уудын хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай байж зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Биелэлт 70
Зорилт 6. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.							
2.8	6.1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах.	6.1.1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.		2021	-	1	Суманд үйл ажиллагаа явуулж буй ТББ болох Ахмадын хорооноос сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж хэлэлцүүлж зохион байгуулсан. Мөн "Ахмадаа сонсоё" сэдэвт төрийн захиргааны үйлчилгээтэй холбоотой хэлэлцүүлгийг сумын ахмадын хороо, ЗДТГ-тай хамтран зохион байгуулж гарсан санал, шүүмжлэл, сайшаал зэрэгт тулгуурлан ахмадын хорооноос Зөвлөмж гаргасан. Биелэлт 100

түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	6.1.2. Сум, байгууллагын түвшинд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоог бууруулах, таслан зогсоох.	авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоог бууруулах, таслан зогсоох.	2021	2	5	Төрийн байгууллагууд авлигаас ангид байх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган сумын Засаг даргаас 8 төсвийн шууд захирагчтай гэрээг байгуулсан. Хагас жилээр үр дүнг тооцон ажилласан. Төрийн албан хаагчдад Авлигын эсрэг хуулийн 10-р зүйлд заасан 13 төрлийн хориглолт, хязгаарлалтын талаар мэдээллийг тогтмол хүргэж хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч ажилласан. Мөн албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтаныг томилох чиглэлийг удирдлагуудад зөвлөмж чиглэл хүргүүлж ажилласан. ХАСУМ-ийг хянаагүй зөрчилтэй томилгоо хийгдээгүй. 2022 оны 10 сарын байдлаар 5 албан хаагчийн ХАСУМ хянуулсан. Үүнээс 2 нь хариу ирсэн 3 нь хяналтын шатацдаа байна. Биелэлт 100
	6.1.3. Засгийн газрын 2021 оны 109 дүгээр "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах.	журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2021	-	1	Төрийн байгууллага бүр байгууллагын үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон сумын цахим хуудсаар ил тод нээлттэй мэдээлж, санхүүгийн үйл ажиллагааг шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хуулийн дагуу байршуулж хэвшсэн. Сумын цахим хуудсыг шилэн дансны мэдээлэлтэй холбосон. Малын тоо толгойн албан татварын хэмжээг багасгах талаар ард иргэдээс удаа дараа санал гарч байсан учраас татварын хэмжээг өөрчлөх санал асуулга хэлэлцүүлэгийг Захирагчны ерөнхий хуулийн дагуу 10 сард 3 хэсэгт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Авлигын эсрэг хуулиар 4 ш постер бэлдэж сумын цахим хуудас, пайж хуудас, цахим сүлжээнд байршуулан. Биелэлт 70

		6.1.4.Сум, агентлагуудын албан ёсны цахим хуудас ашиглалтыг сайжруулах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тодорхой хөрөнгө мөнгө шийдвэрлэн, зарцуулах.	албан ёсны цахим хуудас ашиглалтыг сайжруулах, авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хөрөнгө мөнгө шийдвэрлэн, зарцуулах.	2021	200,0	250,0	Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны урд оны тайлан, 2021 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагдах хөрөнгө мөнгийг 2022 оны төсөвт/сургалтын зардал/ тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Биелэлт 100%
Зорилт 7. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх.							
2.9	7.1.Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус	7.1.1.Төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах.	Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байна.	2021	8	8	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд ХШҮ хийхдээ байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тухай бүр тооцон үйл ажиллагааг нь сайжруулах чиглэл өгч ажиллаж байна. Биелэлт 70%

байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	7.1.2.Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтарч ажиллах.	Нийгэмд Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх	2021	1	2	Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн сурагчид, ард иргэдэд эрх зүйн хөтчөөр дамжуулан сургалт мэдээллийн ажлыг хийж ажилласан. Сумын Хамтарсан багийн пэйж хуудас болон өөрийн цахим хуудсаар дамжуулан "Авлигын эсрэг хуулийн зарим зүйл заалтуудыг бусад цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчилан ажиллаж байна. ЕБС-ийн дотуур байрны 36, 9-12 дугаар ангийн 47 сурагчдад Авлигын эсрэг сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 83 хүүхэд хамруулсан.
НИЙТ ҮНЭЛГЭЭ						Биелэлт 100 91,9%

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА

/ Б.ИЧИННОРОВ /

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА

/ Б.СУГАР /

